



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 769

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2021, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 1,035,434,851.68 (нэг тэрбум гучин таван сая дөчин дөрвөн мянга, найман зуун тавин нэгэн төгрөг, жаран найман мөнгө) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь

1. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2021, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 628 дугаар тогтоолын 3.6 дахь заалтын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар ирүүлэх;

2.2. Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

2.3. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

3. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Н.Мөнгөнхөлөгт)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.2. Компанийн эрх үйл ажиллагааны чиглэлд орсон нэмэлт өөрчлөлтийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр компанийн гэрчилгээ, дүрэмд тухай бүр оруулж байх;

123007366
36-r huraldaan.docx

3.3.Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эд хөрөнгийг бусдад түрээслүүлснээс олсон орлогоос 4,699,393.00 (дөрвөн сая зургаан зуун ерэн есөн мянга гурван зуун ерэн гурван төгрөг) төгрөгийг Улсын төсөвт 2023 оны санхүүгийн жилд багтаан төвлөрүүлэх;

3.4.Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1023 нэр төрлийн 2,960.08 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнөөс цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг актлах талаар холбогдох арга хэмжээ авч, санал боловсруулан Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.5.Удирдах албан тушаалтны орон сууцны түрээсийн төлбөрийг олгосон зөрчлийг давтан гаргасан байх бөгөөд зөрчлийг таслан зогсоож, 2021, 2022 онд олгосон 16,670,000.0 (арван зургаан сая зургаан зуун далан сая төгрөг) төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, компанийг хохиролгүй болгох, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хуулийг мөрдөж ажиллах;

3.6.Худалдан авах ажиллагаанд Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдлөг болгон ажиллаж байх;

3.7.Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

3.8.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 769 дугаар тогтоолын хавсралт

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ, ТҮҮНИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /төгрөг/	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Төрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээслүүлэн, олсон орлогоос Улсын төсөвт төвлөрүүлээгүй	4,699,393.20	Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.
2	Компанийн удирдах 3 ажилтны орон сууцны түрээсийн төлбөрийг байгууллагаас төлж үргүй зардал гаргасан	16,670,000.0	Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.
3	Батлагдсан хөрөнгө оруулалт, ТЗБАХ, их засварын төлөвлөгөөнөөс 16 ажлын гүйцэтгэл нь хэтэрсэн	51,009,869.60	Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллах.
4	Гэрээний дүнгээс хэтрүүлэн худалдан авалт хийсэн шатахуун	963,055,588.88	
5	69 нэгж талбарын эзэмших эрхийн газрын гэрчилгээг албажуулж, санхүүгийн тайланд үнэлж, тусгах	78,512 м.кв талбай бүхий газар	Эзэмших эрхийн газрын гэрчилгээг албажуулах, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч үнэлэн, санхүүгийн тайланд тусгах
ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НИЙТ ДҮН		1,035,434,851.68	(Нэг тэрбум гучин таван сая дөчин дөрвөн мянга, найман зуун тавин нэгэн төгрөг, жаран найман мөнгө)